"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ"
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2024 оны 01 сарын 08 өдөр Дугаар 01 Хэрлэн сум

"Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

**ХЭЛЭЛЦСЭН нь:**

Компанийн 2024 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг дэмжих тухай

**ТЭМДЭГЛЭСЭН нь:**

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам", Эрчим хүчний сайдын 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/17 дугаар тушаал, 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/16 тоот албан бичгээр ирүүлсэн удирдамжийн дагуу компанийн 2024 оны бараа, ажил үйлчилгээг худалдан авах төлөвлөгөөг Төлөвлөлт, худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга А.Төгсмандах танилцуулав.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

1.Компанийн 2024 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд хэлэлцэн дэмжив;

2."Компанийн 2024 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг холбогдох хууль журмын дагуу Эрчим хүчний яам, Сангийн яамаар тус тус батлуулах, хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажиллахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт;

3.Компанийн 2024 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Шилэн дансны цахим системд хуулийн хугацаанд байршуулах, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хагас бүтэн жилээр Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт үүрэг болгов" гэжээ.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ В.ДАРХАНБААТАР

ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ХХК ДОРНОД БҮСИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ТТР0374 ☎ 2628651
ДОРНОД АЙМАГ

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2024 оны 03 сарын 19 өдөр Дугаар 02 Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хурлын тэмдэглэлд:

**ХЭЛЭЛЦСЭН нь:**

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны ажлын тайлангийн тухай

**ТЭМДЭГЛЭСЭН нь:**

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 онд нийт 14 удаа хуралдан 33 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 25 тогтоол, 8 тэмдэглэлээр холбогдох албан тушаалтнуудад үүрэг даалгавар өгсөн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны шийдвэрийн биелэлт 99% байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

“Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны ажлын тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон нарийн бичгийн дарга нарт тус тус даалгав” гэжээ.

ДАРГА О.ХУЯГЦОГТ

"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ"
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 17 өдөр Дугаар 11 Хэрлэн сум

Компанийн ажилтнуудад 2023 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр олгох нэмэгдлийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийн 3.6, "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн дүрмийн 7.3.17, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн дүгнэлт, Эрчим хүчний сайдын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн а/1108 тоот албан бичгээр ирүүлсэн удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Компанийн 2023 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтийг харгалзан ажилтнуудад 2023 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр олгох нэмэгдэл хөлсний дээд хэмжээг 3 сараар тогтоосугай.

2.Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр олгох нэмэгдэл хөлсийг батлагдсан санд багтаан холбогдох журмын дагуу тооцож олгохыг Гүйцэтгэх захирал (Г.Отгонбаатар)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо (Б.Мөнхбаатар)-д үүрэг болгосугай.

ЭРЧИМ ХҮЧНИЙ
ДОРНОД БҮСИЙН
ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ
ЗӨВЛӨЛ
ДОРНОД АЙМАГ

ДАРГА О.ХУЯГЦОГТ

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 30 өдөр Дугаар 15 Хэрлэн сум

Компанийн бүтэц, зохион байгуулалтыг
өөрчлөн тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.4 дэх заалт, Эрчим хүчний сайдын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн а/1269 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн зохион байгуулалтын шинэчлэгдсэн бүтцийг нэгдүгээр хавсралтаар, ажилтан, албан хаагчдын орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Компанийн шинэчлэн батлагдсан бүтэц, зохион байгуулалтыг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Отгонбаатар)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 18 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК-ИЙН ДОРНОД БҮСИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТР0371 ... 2628051 ДОРНОД АЙМАГ

ДАРГА О.ХУЯГЦОГТ

"Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 02 дугаар тогтоолын 1-р хавсралт

"Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн Зохион байгуулалтын бүтцийн схем



"Дорнод бүсийн эрчим хүчний систем"
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2024 оны 04 дүгаар сарын 30-ны өдрийн 15
дугаар тогтоолын 2-р хавсралт

# "ДБЭХС" ТӨХК-ИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ӨӨРЧЛӨЛТӨӨР НЭГЖ ХЭСГҮҮДЭД АЖИЛЛАХ АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН ОРОН ТОО

| д/д | Компанийн нэгж, хэсгийн нэр | Орон тоо | | | Бүгд |
|---|---|---|---|---|---|
| | | Удирдлага | ИТА | Ажилтан | |
| 1 | Удирдлага | 2 | | | 2 |
| 2 | Дотоод аудитор | 1 | | | 1 |
| 3 | Захиргаа, хүний нөөцийн хэлтэс | 1 | 6 | | 7 |
| 4 | Санхүү, эдийн засгийн хэлтэс | 1 | 12 | | 13 |
| 5 | Худалдан авах ажиллагааны хэлтэс | 1 | 5 | | 6 |
| 6 | Хяналт, аюулгүй ажиллагааны хэлтэс | 1 | 10 | | 11 |
| 7 | Нийтлэг үйлчилгээний хэлтэс | 1 | 6 | | 7 |
| 8 | Үйлдвэрлэл, шуурхай ажиллагааны алба | 1 | 14 | | 15 |
| 9 | Техникийн бодлогын хэлтэс | 1 | 6 | | 7 |
| 10 | Эрчим хүч борлуулалтын хэлтэс | 1 | 16 | 38 | 55 |
| 11 | Сүхбаатар ЦТС салбар | 1 | 18 | 67 | 86 |
| 12 | Түлш дамжуулах цех | 1 | 8 | 63 | 72 |
| 13 | Зуухан цех | 1 | 12 | 101 | 114 |
| 14 | Турбин цех | 1 | 12 | 61 | 74 |
| 15 | Хими цех | 1 | 7 | 28 | 36 |
| 16 | Цахилгаан цех | 1 | 12 | 38 | 51 |
| 17 | К-ДХА цех | 1 | 11 | 19 | 31 |
| 18 | Цахилгаан шугам сүлжээний цех | 1 | 6 | 66 | 73 |
| 19 | Дулааны шугам сүлжээний цех | 1 | 1 | 15 | 17 |
| 20 | Бэлтгэх хэсэг | | | 15 | 15 |
| 21 | Үйлчилгээний ажилтнууд | | | 19 | 19 |
| 22 | Автограж | | | 25 | 25 |
| 23 | Төслийн нэгж | | 10 | | 10 |
| | Бүгд | 20 | 172 | 555 | 747 |

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
**ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2024 оны 08 сарын 05 өдөр Дугаар 06 Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

**ХЭЛЭЛЦСЭН нь:**

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцын талаар

**ТЭМДЭГЛЭСЭН нь:**

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангахад үндсэн болон туслах тоноглолын их засварт 4 багц ажил төлөвлөж 88%-ийн гүйцэтгэлтэй, хөрөнгө оруулалтаар 16 багц ажил төлөвлөж 94%-ийн гүйцэтгэлтэй, техник зохион байгуулалтын арга хэмжээний 2 багц ажил төлөвлөж 100%-ийн гүйцэтгэлтэй байна. 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар компанийн өвөлжилтийн бэлтгэл ажил дунджаар 94%-ийн биелэлттэй, санхүүжилтийн гүйцэтгэл 61% байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

”Компанийн 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд гүйцэтгэл дутуу байгаа ажлыг төлөвлөгөөний дагуу чанартай хийж, 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор дуусган, биелэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Г.Отгонбаатар)-т үүрэг болгов” гэжээ.

ДАРГА О.ХУЯГЦОГТ

ЭРЧИМ ХҮЧ... ДОРНОД БҮСИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТР0374 ... 2628651 ДОРНОД А...

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2024 оны 08 сарын 20 өдөр Дугаар 19 Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн 2024 оны техник, эдийн засгийн
үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.1 дэх заалт, Эрчим хүчний сайдын 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн а/2527 дугаар албан бичгээр ирүүлсэн удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний нэмэлт, өөрчлөлтийг нэгдүгээр хавсралтаар, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус дэмжсүгэй.

2.Хавсралтаар дэмжигдсэн төлөвлөгөөг холбогдох байгууллагуудад хүргүүлэн батлуулахыг Гүйцэтгэх захирал (Г.Отгонбаатар)-д даалгасугай.

3.Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Отгонбаатар)-д үүрэг болгосугай.

ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК-ИЙН ДОРНОД БҮСИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ДОРНОД АЙМАГ

ДАРГА О.ХУЯГЦОГТ

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн
19 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

# "ДБЭХС" ТӨХК-ИЙН 2024 ОНЫ ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

| д/д | Үзүүлэлт | | Хэмжих нэгж | 2023 он | 2024 | | 2024 төл | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | анх.төлөв | тод.төл | дүн | хувиар |
| 1 | **ЦЭХ боловсруулалт** | | **сая. кВтц** | **248.9** | **337.2** | **301.0** | **- 36.2** | **89.3%** |
| 2 | ДХЦЭХ | хувиар | **хувь** | **13.18%** | **13.20%** | **13.66%** | **0.5%** | **103.5%** |
| | | биет | сая. кВтц | 32.81 | 44.52 | 41.13 | **- 3.4** | **92.4%** |
| 3 | **Нийт түгээх ЦЭХ** | | **сая. кВтц** | **296.0** | **322.1** | **317.7** | **- 4.5** | **98.6%** |
| | Үүнээс: | Өөрийн түгээх ЦЭХ | сая. кВтц | 216.0 | 292.6 | 259.9 | **- 32.8** | **88.8%** |
| | | ХАЦЭХ-ДҮТ | сая. кВтц | 79.7 | 29.3 | 57.5 | **28.2** | **196.4%** |
| | | Импортын ЦЭХ | сая. кВтц | 0.237 | 0.256 | 0.346 | **0.1** | **135.2%** |
| **4** | **Түгээх ДЭХ** | | **мян.Гкал** | **330.7** | **325.7** | **344.0** | **18.3** | **105.6%** |
| 5 | Шугамын алдагдал | хувиар | хувь | **4.99%** | **4.60%** | **5.82%** | 1.22% | 126.4% |
| | | биет | сая. кВтц | 14.8 | 14.83 | 18.49 | 3.7 | 124.7% |
| 7 | **Нийт орлого** | | **сая.төг** | **72,790.9** | **76,693.7** | **72,995.5** | -3,698.2 | 95.2% |
| | Үүнээс: | Борлуулалтын орлого | сая.төг | 66,502.7 | 75,715.4 | 72,017.2 | **-3,698.2** | 95.1% |
| | | Бусад орлого | сая.төг | 6,288.2 | 978.3 | 978.3 | - | 100.0% |
| 8 | **Нийт зардал** | | **сая.төг** | **67,523.7** | **78,829.2** | **82,375.7** | 3,546.4 | 104.5% |
| | Үүнээс: | Үйл ажиллагааны зардал | сая.төг | 51,064.5 | 75,515.8 | 70,038.9 | **-5,476.9** | 92.7% |
| | | ХАЦЭХ-ний өртөг | сая.төг | 10,765.9 | 2,601.1 | 11,624.4 | **9,023.3** | 446.9% |
| | | Бусад зардал | сая.төг | 5,693.3 | 712.3 | 712.3 | - | 100.0% |
| 9 | **Татвар төлөхийн өмнөх ашиг, /алдагдал/** | | **сая.төг** | **5,267.2** | **(2,135.56)** | **(9,380.14)** | -7,244.6 | 439.2% |
| 10 | **Татварын дараах цэвэр ашиг /алдагдал /** | | **сая.төг** | **4,755.2** | **(2,135.56)** | **(9,380.14)** | -7,244.6 | 439.2% |
| 11 | БО-ын 1 төгрөгт ногдох зардал | | **төг** | 0.928 | 1.028 | 1.129 | 0.1 | 109.8% |
| 12 | **Нийт авлага** | | **сая.төг** | **41,427.6** | **3,415.0** | **3,415.0** | - | 100.0% |
| | Үүнээс: | ЭХ-ний авлага | сая.төг | 1,543.4 | 1,758.0 | 1,758.0 | - | 100.0% |
| | | бусад | сая.төг | 39,884.2 | 1,657.0 | 1,657.0 | - | 100.0% |
| 13 | **Нийт өглөг** | | **сая.төг** | **127,893.6** | **211,705.2** | **220,705.3** | 9,000.1 | 104.3% |
| | Үүнээс: | УХӨТ | сая.төг | 114,379.8 | 204,370.2 | 204,370.2 | 0.0 | 100.0% |
| | | БХӨТ | сая.төг | 13,513.9 | 7,335.0 | 16,335.0 | 9,000.0 | 222.7% |
| **14** | **Нийт ажилтан** | | **сая.төг** | **615** | **620** | **737** | 117.0 | 118.9% |
| **15** | **Нийт цалингийн сан** | | **сая.төг** | **19,630.06** | **25,975.45** | **27,515.92** | 1,540.5 | 105.9% |
| **16** | **Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ** | | **сая.төг** | **5,611.5** | **3,779.2** | **3,751.7** | - 27.6 | 99.3% |

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн
19 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

# "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ"ТӨХК-ИЙН 2024 ОНЫ ИХ ЗАСВАР, ТЕХНИК ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| д/д | Гүйцэтгэх ажил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгж өртөг /мян. төг/ | Анх.төлөв /мян.төг/ | Тод.төлөв /мян.төг/ |
|---|---|---|---|---|---|---|
| **1.ИХ ЗАСВАР** | | | | | | |
| 1 | Конвейер №3Б ремейн | ком | 1 | 103,776.0 | 103,776.0 | 103,776.0 |
| 2 | Зуух №3 | ком | 1 | 695,553.0 | 695,553.0 | 695,553.0 |
| 3 | Зуух №4 уур халаагчийн 1,2-р үе солих | ком | 1 | 675,682.0 | 675,682.0 | 675,682.0 |
| 4 | Турбогенератор №3 | ком | 1 | 403,075.0 | 403,075.0 | 403,075.0 |
| 5 | Секц холбогч-яч-58 яч-84 реакторын шунт хуурай салгуур | ком | 2 | 2,200.0 | - | 4,400.0 |
| | **Их засварын дүн** | | | | **1,878,086.0** | **1,882,486.0** |
| **2.ТЗБАХ** | | | | | | |
| 1 | 10кВ-ын Дашбалбар ЦДАШ буулгах ажлын хөлс | ком | 1 | 127,978.0 | 127,978.0 | 127,978.0 |
| 2 | Камерын хяналтын систем суурилуулах | ком | 1 | 17,249.0 | 17,249.0 | 17,249.0 |
| | **ТЗБАХ-ийн дүн** | | | | **145,227.0** | **145,227.0** |
| **3.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | | | | | | |
| 1 | Турбины нөөц сэлбэг | ком | 1 | 560,000.0 | 560,000.0 | - |
| 2 | Үндсэн бойлерын зүрхэвчний гуулин хоолой | ком | 1 | 150,000.0 | 150,000.0 | 150,000.0 |
| 3 | Эсрэг осмосын мембран шүүр | ш | 48 | 3,125.0 | 150,000.0 | 150,000.0 |
| 4 | Кварцын элс | тн | 25 | 5,000.0 | 125,000.0 | 125,000.0 |
| 5 | Дулааны хянах хэмжих хэрэгсэл | ком | 1 | 160,540.0 | 160,540.0 | 160,540.0 |
| 6 | Дулааны II магистраль шугам | ком | 1 | 269,270.0 | 269,270.0 | 269,270.0 |
| 7 | Зуухны тээрмийн алх баригч | ш | 300 | 190.0 | 57,000.0 | 57,000.0 |
| 8 | Зуухны нүүрс тэжээгчийн гинж | ком | 2 | 19,000.0 | 38,000.0 | 38,000.0 |
| 9 | Цахилгаан тоноглол | ком | 14 | 5,665.4 | 79,315.0 | 79,315.0 |
| 10 | Компьютер техник хэрэгсэл | ком | 1 | 43,500.0 | 43,500.0 | 43,500.0 |
| 11 | Цахилгаан дамжуулах агаарын шугам, | ком | 1 | 31,125.0 | 31,125.0 | 31,125.0 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 12 | Трансформатор 30кВА 10/0.4 | ком | 1 | 15,500.0 | 15,500.0 | 15,500.0 |
| 13 | Краны төхөөрөмж | ком | 1 | 35,000.0 | 35,000.0 | 35,000.0 |
| 14 | Богино долгионы станц | ком | 1 | 13,475.0 | 13,475.0 | 13,475.0 |
| 15 | Хэргэлтийн төхөөрөмж | ком | 2 | 6,600.0 | 13,200.0 | 13,200.0 |
| 16 | Цайны газрын тоног төхөөрөмж | ком | 1 | 15,000.0 | 15,000.0 | 15,000.0 |
| 17 | НМШ8-25-6.3/25 мазутын араат насос | ком | 2 | 15,000.0 | - | 30,000.0 |
| 18 | Төмөр бетон тулгуур | ш | 69 | 1,215.9 | - | 83,900.0 |
| 19 | Цахилгаан шугам, дэд станцын засвар үйлчилгээ | ком | 1 | 80,000.0 | - | 80,000.0 |
| 20 | Hyundai Mega Truck 5tn өөрөө буулгагч | ш | 1 | 85,000.0 | - | 85,000.0 |
| 21 | Суудлын автомашин /ланд крузер78/ | ш | 1 | 140,000.0 | - | 140,000.0 |
| 22 | Цаг бүртгэлийн систем / ABLE XXK | ком | 1 | 45,000.0 | - | 45,000.0 |
| 23 | Эх бэлтгэх хэвлэлийн төхөөрөмж /канон, принтер, цаас устгагч | ш | 3 | 1,481.9 | - | 4,445.8 |
| 24 | Шалган нэвтрүүлэх байр, харуулын цэгүүдэд шаардлагатай тусгай хэрэгсэл | ком | 1 | 14,200.0 | - | 14,200.0 |
| 25 | Цайны газрын техник хэрэгсэл | ком | 1 | 19,000.0 | - | 19,000.0 |
| 26 | Аваарийн нөөц /хүчний трансформатор, UPS төхөөрөмж, реле хамгаалалт/ | ш | 4 | 6,625.0 | - | 26,500.0 |
| | **Хөрөнгө оруулалтын дүн** | | | | **1,755,925.0** | **1,723,970.8** |
| | **НИЙТ ДҮН** | | | | **3,779,238.0** | **3,751,683.8** |

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2024 оны 08 сарын 20 өдөр Дугаар 07 Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

**ХЭЛЭЛЦСЭН нь:**

Компанийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийн тухай

**ТЭМДЭГЛЭСЭН нь:**

Компани 2024 оны эхний хагас жилд 157.7 сая.кВтц цахилгаан түгээж төлөвлөгөөнөөс 3 сая.кВтц буюу 1.9%-аар, 200.6 мян.Гкал дулааны эрчим хүч түгээж, төлөвлөгөөнөөс 17.7 мян.Гкал буюу 9.7%-аар давуулан биелүүлсэн байна.

2024 оны хагас жилд нийт 39,730.7 сая төгрөгийн зардал гаргаж, нийт 40,159.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөт ашгийг 1,112.2 сая төгрөгөөр бууруулж татварын дараа 428.50 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

“Компанийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг бүрэн хангах, ашигт ажиллагаа, үр ашгийг дээшлүүлэх, авлагыг бууруулах, өр төлбөрийг тогтоосон хугацаанд нь барагдуулах талаар дараах арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт даалгав.

1. Компанийн Мөнгөн урсгалын хүлээгдэж буй гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, өр, авлагыг бууруулах, цаашид санхүүгийн чадавхийг сайжруулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, үр дүнг танилцуулах;

2. 2024 оны эхний хагас жилд үйл ажиллагааны зардал өссөн, орлого буурсан тул компанийн техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн тодотгол хийлгэх, үр ашгийг нэмэгдүүлэх;

ЭРЧИМ ХҮЧНИЙ ДОРНОД БҮСИЙН СИСТЕМ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ДАРГА О.ХУЯГЦОГТ

580022013

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2024 оны 08 сарын 20 өдөр Дугаар 08 Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

**ХЭЛЭЛЦСЭН нь:**

Компанийн 2024 оны худалдан авах төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийн явц

**ТЭМДЭГЛЭСЭН нь:**

Компанийн 2024 оны худалдан авах төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийн явцын талаар Худалдан авах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн А.Төгсмандах танилцуулав.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь 2024 онд нийт 80 худалдан авалт хийхээр төлөвлөснөөс 74 худалдан авалтын гэрээ байгуулж, 44 гэрээг бүрэн дуусгаж дүгнэсэн ба 6 гэрээ хугацаа дуусаагүй, 22 гэрээ жилийн эцэс хүртэл болон бүтэн жилийн хугацаатай байгуулагдан хэрэгжиж байна. Гадаадын зах зээлийн хүчин зүйлээс шалтгаалан 7 гэрээний хугацааг сунгасан ба хугацаа сунгасан гэрээнүүдээс 4 гэрээг дуусгаж дүгнэсэн байна.

2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 85% байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах биелүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт үүрэг болгов” гэжээ

ДАРГА О.ХУЯГЦОГТ

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2024 оны 09 сарын 25 өдөр Дугаар 25 Хэрлэн сум

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2, 31.3.1, 31.3.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2, 1.4, 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болсон хавсралтад заасан 51 нэр төрлийн 1,329,488,963.95 (Нэг тэрбум гурван зуун хорин есөн сая дөрвөн зуун наян найман мянга есөн зуун жаран гурван төгрөг ерэн таван мөнгө) төгрөгийн балансын үнэтэй, 1,298,248,673.90 (Нэг тэрбум хоёр зуун ерэн найман сая хоёр зуун дөчин найман мянга зургаан зуун далан гурван төгрөг ерэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 31,240,290.05 (Гучин нэгэн сая хоёр зуун дөчин мянга хоёр зуун ерэн төгрөг таван мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хөрөнгийг акталж, үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасах саналыг дэмжсүгэй.

2.Актлах саналтай үндсэн хөрөнгийн холбогдох материалыг Эрчим хүчний яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулж ажиллахыг гүйцэтгэх захиралд даалгасугай.

ДАРГА О.ХУЯГЦОГТ

"Дорнод бүсийн эрчим хүчний систем"
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн
25 дугаар тогтоолын хавсралт

## "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨХК-ИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ ДАСНААС ХАСАХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Хөрөнгийн нэр, марк | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Ашиглалтад орсон огноо | Балансын нэг бүрийн үнэ | Балансын Нийт үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг | Санал /актлах, худалдах, шилжүүлэх/ | Акталсан | Данснаас хасах болсон |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | (төгрөг) | | | | | | |
| | | | | | Тоног төхөөрөмж | | | | | | |
| 1 | Агаар халаагчийн 2-р үе Зуух ¹3 ТП-35 | шир | 1 | 2020-04-15 | | 79,504,390.53 | 66,899,803.14 | 12,604,587.39 | Актлах | | |
| 2 | Коллекторын даралт 0-100 бар | шир | 1 | 2003-01-01 | | 3,903,617.00 | 3,903,617.00 | 0.00 | Актлах | | |
| 3 | Гүйцэтгэх механизм МЭО-1600/25 | шир | 2 | 2011-11-30 | | 3,000,000.00 | 3,000,000.00 | 0.00 | Актлах | | |
| 4 | АУМА гүйцэтгэх механизм /Х-63-2/450 0,18кВт:P-sa0.75-feo 22.8min/ | шир | 1 | 2011-10-31 | | 1,600,000.00 | 1,600,000.00 | 0.00 | Актлах | | |
| 5 | ТГ-4Отборын хамгаалах клапан | шир | 1 | 1999-01-01 | | 25,396,636.00 | 25,396,636.00 | 0.00 | Актлах | | |
| 6 | Маслын центрфуг | шир | 1 | 1980-01-01 | | 15,871,557.00 | 15,871,557.00 | 0.00 | Актлах | | |
| 7 | ТГ-2Үндсэн эжектор ЭО-30 | шир | 1 | 1969-01-01 | | 148,731,723.00 | 148,731,723.00 | 0.00 | Актлах | | |
| 8 | ТГ-4 Үндсэн эжектор ЭО-30 | шир | 1 | 1999-01-01 | | 142,534,568.00 | 142,534,568.00 | 0.00 | Актлах | | |
| 9 | ТГ-2Явуулах эжектор ЭП-150 | шир | 1 | 1969-01-01 | | 148,731,723.00 | 148,731,723.00 | 0.00 | Актлах | | |
| 10 | ТГ-4 Тохируулгын блок П-6-35/5 | шир | 1 | 1999-01-01 | | 520,404,907.00 | 520,404,907.00 | 0.00 | Актлах | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | UPS online | шир | 1 | 2016-12-30 | | 4,919,480.00 | 4,919,480.00 | 0.00 | Актлах | | |
| 12 | Зөөврийн доргио хэмжигч BV450 extech | шир | 1 | 2018-10-31 | | 4,800,000.00 | 4,800,000.00 | 0.00 | Актлах | | |
| 13 | Ширээний өрөм ДА-1-5 | шир | 1 | 1969-01-01 | | 23,971.00 | 23,971.00 | 0.00 | Актлах | | |
| 14 | Богино долгионы гар утас | шир | 3 | 2019-04-01 | | 2,904,000.00 | 2,904,000.00 | 0.00 | Актлах | | |
| 15 | Тос турших төхөөрөмж АИИ-90 | шир | 1 | 2013-09-30 | | 1,500,000.00 | 1,500,000.00 | 0.00 | Актлах | | |
| 16 | Уулбаян ДС-ын Элегаз таслуур 35кВ ST-14RDL-100 | шир | 1 | 2003-11-08 | | 50,809,920.00 | 50,809,920.00 | 0.00 | Актлах | | |
| | | | 19 | | | 1,154,636,492.53 | 1,142,031,905.14 | 12,604,587.39 | | | |
| | **Компьютер, техник хэрэгсэл** | | | | | | | | | | |
| 1 | Принтер laser HP LJ-p1102 | шир | 1 | 2012-03-31 | 160,909.00 | 160,909.00 | 160,909.00 | 0.00 | Актлах | | |
| 2 | Принтер NP Laserjet pro M130A | шир | 1 | 2018-04-30 | 422,910.00 | 422,910.00 | 422,910.00 | 0.00 | Актлах | | |
| 3 | Компьютерийн дэлгэц 19инч dell | шир | 2 | 2015-08-31 | 195,000.00 | 390,000.00 | 390,000.00 | 0.00 | Актлах | | |
| 4 | Хурууны хээ уншигч Цаг бүртгэл Iclock 360 | шир | 2 | 2018-02-28 | 474,500.00 | 949,000.00 | 949,000.00 | 0.00 | Актлах | | |
| 5 | Компьютерын процессор/Үйлдвэрийн зориулалттай сервер A,B/ | шир | 2 | 2009-12-31 | 2,462,243.00 | 4,924,486.00 | 4,924,486.00 | 0.00 | Актлах | | |
| 6 | Компьютерийн дэлгэц LCD 19инч DELL | шир | 3 | 2012-03-31 | 172,727.27 | 518,181.82 | 518,181.82 | 0.00 | Актлах | | |
| 7 | Принтер Dot matrix PR2 10 | шир | 2 | 2015-06-30 | 1,000,000.00 | 2,000,000.00 | 2,000,000.00 | 0.00 | Актлах | | |
| 8 | Сүлжээний сэлгэн залгагч /8-н порттой/ | шир | 2 | 2016-03-01 | 380,000.00 | 760,000.00 | 760,000.00 | 0.00 | Актлах | | |
| 9 | Эйр кондейшн GVA48AH M3NNA5A | ком | 1 | 2018-09-30 | 6,613,200.00 | 6,613,200.00 | 6,613,200.00 | 0.00 | Актлах | | |
| 10 | Канон сканертай 110 | шир | 1 | 2014-02-25 | 227,300.00 | 227,300.00 | 227,300.00 | 0.00 | Актлах | | |
| 11 | Нөтбүк toshlt-PSC6CL-00D002-C800 | шир | 1 | 2014-02-25 | 818,200.00 | 818,200.00 | 818,200.00 | 0.00 | Актлах | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | Хяналтын гадна камер DS-21-77A WD | ком | 7 | 2018-08-31 | 198,000.00 | 1,386,000.00 | 1,386,000.00 | 0.00 | Актлах | | |
| 13 | Принтер м125A | шир | 1 | 2017-01-01 | 561,000.00 | 561,000.00 | 561,000.00 | 0.00 | Актлах | | |
| 14 | Зөөврийн компьютер /Dell inspiron 5570 i7/ | шир | 1 | 2018-04-30 | 2,700,910.00 | 2,700,910.00 | 2,700,910.00 | 0.00 | Актлах | | |
| 15 | Зөөврийн компьютер /Dell inspiron 5570 i7/ | шир | 1 | 2018-04-30 | 2,700,910.00 | 2,700,910.00 | 2,700,910.00 | 0.00 | Актлах | | |
| 16 | Компьютер дэлгэц Acer B243 24инч LCD | шир | 1 | 2018-08-31 | 308,000.00 | 308,000.00 | 308,000.00 | 0.00 | Актлах | | |
| 17 | Нөтбүк toshiba-00M003 C50 | шир | 1 | 2014-02-25 | 1,090,900.00 | 1,090,900.00 | 1,090,900.00 | 0.00 | Актлах | | |
| 18 | Тог баригч 1200 | шир | 1 | 2008-01-01 | 253,000.00 | 253,000.00 | 253,000.00 | 0.00 | Актлах | | |
| | | | 31 | | | 26,784,906.82 | 26,784,906.82 | 0.00 | | | |
| **Тавилга, эд хогшил** | | | | | | | | | | | |
| 1 | Бичгийн ширээ | шир | 1 | 2004-01-01 | 77,610.00 | 77,610.00 | 77,610.00 | 0.00 | Актлах | | |
| 2 | Хүрэн ширээ | шир | 1 | 2006-01-01 | 126,540.00 | 126,540.00 | 126,540.00 | 0.00 | Актлах | | |
| 3 | Сандал /эргэдэг дугуйтай, хар/ | шир | 1 | 2016-04-01 | 275,467.50 | 275,467.50 | 222,014.23 | 53,453.27 | Актлах | | |
| 4 | Сандал /эргэдэг дугуйтай, хар/ | шир | 1 | 2016-04-01 | 275,467.50 | 275,467.50 | 222,014.23 | 53,453.27 | Актлах | | |
| 5 | Сандал | шир | 4 | 2017-02-01 | 55,000.00 | 220,000.00 | 163,088.77 | 56,911.23 | Актлах | | |
| 6 | Компьютерийн ширээ /саарал/ | шир | 1 | 2003-01-01 | 443,210.00 | 443,210.00 | 443,210.00 | 0.00 | Актлах | | |
| 7 | Сандал | шир | 4 | 2014-03-31 | 45,454.50 | 181,818.00 | 181,818.00 | 0.00 | Актлах | | |
| 8 | Кондишн хүйтэн халуун үлээгчтэй | ком | 1 | 2015-06-25 | 3,500,000.00 | 3,500,000.00 | 3,500,000.00 | 0.00 | Актлах | | |
| 9 | Сандал /эргэдэг дугуйтай, хар/ | шир | 1 | 2016-04-01 | 275,467.50 | 275,467.50 | 222,014.23 | 53,453.27 | Актлах | | |
| 10 | Лабораторын ширээ | шир | 2 | 2004-01-01 | 24,450.00 | 48,900.00 | 48,900.00 | 0.00 | Актлах | | |
| 11 | Хэлхээ сандал /4-тэй хүл/ | шир | 1 | 2016-06-01 | 95,000.00 | 95,000.00 | 71,220.60 | 18,239.34 | Актлах | | |
| 12 | Сандал хүрэн | шир | 1 | 2013-06-30 | 200,000.00 | 200,000.00 | 200,000.00 | 0.00 | Актлах | | |
| | Дүн | | 19 | | | 5,719,480.50 | 5,478,430.06 | 235,510.38 | | | |
| **Биет бус хөрөнгө** | | | | | | | | | | | |
| 1 | Цаг бүртгэлийн програм temp-supervisor | шир | 2 | 2018-02-28 | 2,000,000.00 | 4,000,000.00 | 4,000,000.00 | 0.00 | Актлах | | |
| 2 | НБББББ 2016 | шир | 1 | 2016-12-30 | 14,900,000.00 | 14,900,000.00 | 14,900,000.00 | 0.00 | Актлах | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | | 3 | 85,893.00 | 16,900,000.00 | 18,900,000.00 | 18,900,000.00 | 0.00 | | | |
| **Тээврийн хэрэгсэл** | | | | | | | | | | | |
| 1 | Автомашин өөрөө буулгагч CLW5060ZLJ3 25-33ДОР | шир | 1 | 2013-08-31 | | 49,946,380.10 | 31,546,187.82 | 18,400,192.28 | Худалдах | | |
| 2 | Суудлын автомашин УАЗ 22069 77-86ДОА | шир | 1 | 2008-01-01 | | 21,177,322.00 | 21,177,322.00 | 0.00 | Худалдах | | |
| 3 | Автовышка /15-46СУА CLWJGKZ | шир | 1 | 2011-05-31 | 52,324,382.00 | 52,324,382.00 | 52,324,382.00 | 0.00 | Худалдах | | |
| | **Нийт дүн** | | **75** | | | **1,329,488,963.95** | **1,298,248,673.90** | **31,240,290.05** | | | |

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2024 оны 09 сарын 25 өдөр Дугаар 14 Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

**ХЭЛЭЛЦСЭН нь:**

Компанийн 2024 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

**ТЭМДЭГЛЭСЭН нь:**

Компанийн 2024 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг ХААХ-ийн ахлах мэргэжилтэн А.Төгсмандах танилцуулав.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

1.Компанийн 2024 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний нэмэлт, өөрчлөлтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд хэлэлцэн дэмжив;

2.”Төлөвлөгөөний нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль журмын дагуу Эрчим хүчний яам, Сангийн яамаар тус тус батлуулах, хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажиллахыг гүйцэтгэх захиралд;

3.Компанийн 2024 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Шилэн дансны цахим системд хуулийн хугацаанд байршуулах, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захиралд тус тус үүрэг болгов” гэжээ.

ДАРГА О.ХУЯГЦОГТ

580022023